



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/49

Жаргалтхаан

**Тээврийн хэрэгслийн татвар хураалт,
техникийн үзлэг явуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/144 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд авто тээврийн хэрэгслийн татвар хураалт, урьдчилсан үзлэгийг 2024 оны 04 дүгээр сарын 22-26-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураан авах, урьдчилсан үзлэг зохион явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Ганбат – Сумын Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга: А.Оюунтунгалаг – Татварын улсын байцаагч

Гишүүд: Н.Ууганбаяр – Газрын даамал

М.Эрдэнэтуяа- Улсын бүртгэгч

Д.Энхболд – 1 дүгээр багийн Засаг дарга

Э.Аранжал – 2 дугаар багийн Засаг дарга

М.Өсөхжаргал- 3 дугаар багийн Засаг дарга

Б.Мэндбаяр – 4 дүгээр багийн Засаг дарга

Б.Жаргал – 5 дугаар багийн Засаг дарга

А.Бадамсэд - Хэсгийн төлөөлөгч

3.Татварын орлогыг бүрдүүлэх, тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд бүрэн хамруулах, тээврийн хэрэгслийн албан татварыг хураан авах, тээврийн хэрэгслийн техникийн үзлэгийн бэлтгэл ажлыг бүрэн хангах, захирамжийн биелэлтийг хангуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (С.Ганбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ЦЭНГЭЛ



232431117